



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 8/240

Арвайхээр сум

Г Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс  
урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын “Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоо, мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх” тухай тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулах тухай” 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/87 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үхэр, гахайн сүргийн хаврын дархлаажуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Үхэр, гахайн сүргийг дархлаажуулах ажил эхэлж байгаатай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-нд заасан “Малын тоо, толгойн албан татвараас 30 хуртэл хувийг мал аж ахуйн эрүүл мэндийг хамгаалахад зарцуулна” гэсэн заалтыг орон нутагтаа хэрэгжүүлж, Ажлын хэсэг томилон, шаардлагатай зардлыг төсөвлөж зарцуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Үхэр гахайн сүрэгт хийх мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжилтэй арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дунд хяналт тавьж, дүнг танилцуулж, холбогдох газар хүргүүлэхийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0455

D:My Doc. Zahiramj. Zasag darga